



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 126


Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсгийг
ТУШААХ нь:

1. Зонхилон тохиолдох өвчний үед хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүний үндэсний заавар шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган удирдамжийн дагуу ажиллах зааврыг батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Зэндмаа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080426

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 04 сарын 07 өдрийн
1-дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Л.Зэндмаа Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.
- Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн төрөлжсөн мэргэжлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн.
- Гишүүд:
- Н.Эрдэнэбаяр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал
- Т.Алимаа, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чанарын албаны дарга
- Д.Чулуунцэцэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Гемодиализийн тасгийн эрхлэгч
- С.Хүрэлсүх, Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- Л.Амгалан, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Мэс заслын тасгийн эрхлэгч
- Ж.Ганбаатар, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч
- С.Сувд-Эрдэнэ, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрхний мэс заслын эрхлэгч
- С.Байгалмаа, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- Р.Энхсайхан, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч
- Г.Чимгээ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цусны клиникийн зөвлөх

Г.Баттулга. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн дэд захирал

С.Энхтуяа, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн нярайн тасгийн эрхлэгч

Д.Цэцгээ, Нийслэлийн “Хүрээ” амаржих газрын эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

О.Пүрэвжал, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн цусны тэнхимийн багш

Профессор Смит Сибинга, АХБ-ны ЭМСХХ-5 төслийн цусны аюулгүй байдлын Олон улсын зөвлөх /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 04 сарын 01 өдрийн
1.9.6 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ӨВЧНИЙ ҮЕД ХЭРЭГЛЭХ ЦУС, ЦУСАН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНДЭСНИЙ ЗААВАР ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Монгол улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2008 оны 111-р тогтоолын хэрэгжилтийг хангах

Зорилго:

Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологиуд нэвтэрч байгаатай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, чанар, хүртээмж, зохистой хэрэглээг сайжруулах хүрээнд зааврыг шинэчлэн боловсруулах

Үйл ажиллагааны чиглэл:

1. Мөрдө байгаа цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэх үндэсний зааврыг шинэчлэх талаар Улаанбаатар хот, аймаг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудаар хэлэлцүүлж санал авах
2. Ирсэн саналуудыг тусган төслийг боловсруулж, мэргэжлийн салбар зөвлөлүүдээр хэлэлцүүлж, саналыг тусгах
3. Үндэсний зааврын шинэчилсэн төслийг батлуулах

Хугацаа:

2015 оны 1 сараас 2015 оны 4-р улирал

Хүрэх үр дүн:

Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэх үндэсний заавар шинэчлэгдэн батлагдаж эмнэлзүйн практикт нэвтэрсэнээр цус сэлбэлтэнд оролцдог эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, цус сэлбэх эмчилгээний чанар, хүртээмж, зохистой хэрэглээ сайжрах эрх зүйн орчин бүрдэнэ.